



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй  
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3, 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Волтам” ХХК-ийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 185,578,456 /нэг зуун наян таван сая таван зуун далан найман мянга дөрвөн зуун тавин зургаа/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/-т, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Волтам” ХХК-ийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 139,183,842 /нэг зуун гучин есөн сая нэг зуун наян гурван мянга найман зуун дөчин хоёр/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 13,918,384 /арван гурван сая есөн зуун арван найман мянга гурван зуун наян дөрөв/ ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар нэг бүрийг 360 /гурван зуун жар/ төгрөгөөс 380 /гурван зуун ная/ төгрөгөөр “Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 32,476,230 /гучин хоёр сая дөрвөн зуун далан зургаан мянга хоёр зуун гуч/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 380 /гурван зуун ная/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Волтам” ХХК /Д.Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөлөөр анхдагч зах зээлд худалдахыг “Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК /С.Батчимэг/-д зөвшөөрч, олон нийтэд танилцуулах, сурталчлах болон хувьцааны захиалгыг эхлүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг үүрэг болгосугай.

6. Энэ тогтоолын 3, 4-т заасан нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг 100 /нэг зуу/ хувь худалдсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Волтам” ХХК /Д.Эрдэнэ/-д мэдэгдсүгэй.

7. Санхүүгийн зохицуулах хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

9. Энэ тогтоолын 6-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК /С.Батчимэг/-д анхааруулсугай.

10. “Волтам” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Волтам” ХХК /Б.Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

11. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК /С.Батчимэг/, “Өмгөөллийн Ди Би энд Жи Ти Эс” ХХН /Д.Золжаргал/, “Эрнст энд Янг монголия аудит” ХХК /Г.Алтансүх/, “БДО аудит” ХХК /Г.Баянмөнх/-д тус тус анхааруулсугай.

12. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн  
127 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо ширхэг
1	Б.Баттулга		55,673,537
2	Д.Эрдэнэ		55,673,537
3	Г.Уянга		27,836,768
	Нийт дүн		139,183,842